



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН  
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдөр  
Хурал хуралдсан газар: Монголын Мянганы сорилтын сан, “Туул” хурлын танхим

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурьдсан 8 асуудалтай танилцаж, хэлэлцэн харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулан Удирдах зөвлөлийн чиг үүрэг, хариуцлага болон УЗ-ийн үйл ажиллагаанд хамааралтай дүрэм, журмын талаар АНУ-ын МСК-ын Хуулийн ерөнхий зөвлөхийн газраас мэдээлэл хийв.
2. Удирдах зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэлтэй Удирдах зөвлөлийн гишүүд танилцаж, санал нэгтгэйгээр батлав.
3. Монголын МСС-ийн 2021 оны гүйцэтгэлийн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаар танилцуулав.
4. Монголын МСС-ийн удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн асуудлууд, тухайлбал, Хүний нөөцийн бодлогын баримт бичиг – Хөдөлмөрийн дотоод журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, Нийцлийн төлөвлөгөөний төсөл, Ажилтнуудын цалингийн шатлалыг шинэчлэх асуудал, Бүтэц, зохион байгуулалтад оруулах өөрчлөлтийн төслийг тус тус хэлэлцэж батлав.
5. Монголын МСС-ийн 2021.07.01-нээс 2022.06.30-ны хооронд хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлав.
6. Монголын МСС-ийн 2021 оны 3 дугаар улирлын санхүүжилтийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлав.
7. Монголын МСС-ийн Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлав.
8. Монголын МСС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийж буй зөвлөх компанийн аудитын төлөвлөгөөний тухай танилцуулав.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН